

## ОНОЛ, УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**АЛС ДОРНОД ДАХЬ АНУ-ЫН «ТҮНШЛЭХ»  
БОДЛОГО****Ц. Батбаяр.**

Дэлхийн бөмбөрцгийн бусад районы нэгэн адил Алс Дорнод орчин үеийн олон улсын харилцаанд чухал байр эзэлдэг.

АНУ энэ районд өөрийн нөлөөг хадгалахын тулд бүр 50-иад оноос эхлэн Япон, Өмнөд Солонгостой холбоо тогтоон, тэнд америкийн цэргийн баазууд, зэвсэгт хүчнээ байрлуулах замаар байгуулсан Ази дахь цэрэг-улс төрийн гэрээний системээ хэзээд хадгалах буюу шинэчлэн бэхжүүлэхээр хүчлэн зүтгэж ирэв. Рейганы засаг захиргааны Азийн талаарх стратеги нь зөвлөлтийн эсрэг үзэл нэвт шингэсэн бөгөөд Ази тивийн улс түмний дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох, бус нутаг дахь социализмын байр суурийг хагалан бутаргахад чиглэгджээ.

Тус бүс нутагт өөрийн нөлөөгөө ихэсгэхийг эрмэлзэж байгаа Вашингтоны стратегид Япон урьдын адил гол байр эзэлж байна. Япон-америкийн цэрэг-улс төрийн холбооны эрх зүйн үндэс нь 1960 оны 1 дүгээр сард гарын үсэг зурсан бөгөөд 1970 оноос жил бүр сунгагдаж ирсэн «Аюулгүйн гэрээ»<sup>1</sup> юм. Энэхүү гэрээний VI зүйлийн дагуу АНУ нь Японы нутаг дэвсгэр дээр цэргийн бааз байгуулан зэвсэгт хүчнээ байрлуулах эрх олж авсан юм. Одоогийн байдлаар Японд АНУ-ын 46 мян. орчим цэргийг багтаасан 119 төрөл бүрийн бааз, объект байрлаж байна. 70-аад он гэхэд «аюулгүйн гэрээний» зөвхөн Японыг батлан хамгаалах үндсэн зорилт нь Ази, Номхон далай дахь америкийн цэрэг-стратегийн системд Японыг шууд оролцуулах тал руу хэлбийж ирэв. 1978 оны 11 дүгээр сарын 27-нд болсон аюулгүй байдлын асуудлаархи Япон-америкийн зөвлөлдөх зөвлөлийн XVII хуралдаанаар баталсан «Батлан хамгаалах салбар дахь америк-японы хамтын ажиллагааны үндсэн зарчмуудад»<sup>2</sup> байлдааны ажиллагааны үед японы «өөрийгөө хамгаалах хүч» болон америкийн зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийг тодорхой зааглан зааж өгчээ.

1981 оны 5-р сард Вашингтонд ерөнхийлөгч Рейгантай ерөнхий сайд Сузуки уулзах үед Японы эргээс 1000 милийн зайтай Номхон далайн баруун хойд хэсэгт японы тал тэнгисийн ба агаарын эргүүл хийх асуудлыг авч хэлэлцсэн нь далайн зам харилцааг хамгаалах нэрийдлээр «өөрийгөө хамгаалах хүчний» ажиллагааны хүрээг ихээхэн өргөжүүлж өгсөн юм. 1982 оны 1-р сард дээр дурьдсан зөвлөлдөх зөвлөлийн XVIII хуралдаанаар хоёр орны цэргийн хамтарсан ажиллагааг Номхон далайн баруун хойт хэсгийг хамруулан өргөжүүлэх асуудлыг хэлэлцжээ. Уулзалтын дүнд Алс Дорнодод «онцгой нөхцөл байдал» үүссэн тохиолдолд жишээлбэл хөрш Солонгосын хойгт дайны гал асвал, авч хэрэгжүүлэх хамтын ажиллагааг судлахаар тохирчээ. Энэ нь Японыг

<sup>1</sup> С. И. Вербицкий Японо-американский военно-политический союз М., 1972, с. 273-275.

<sup>2</sup> «Проблемы Дальнего Востока». 1981, № 1, с. 58.

<sup>3</sup> Far Eastern Economic Review 1982. vol. 115, N3.

Пентагоны цэрэг-стратегийн ерөнхий хүрээнд улам татан оруулах нэгэн алхам болсон юм.

«Аюулгүйн гэрээний VI зүйлд «Японы аюулгүй байдлыг, Алс Дорнодын энх тайван ба аюулгүй байдлыг хангах зорилгоор» Япон нь нутаг дэвсгэртээ бааз байрлуулах эрхийг АНУ-д олгосон гэж заажээ.<sup>4</sup> Вашингтоны даралт шахалтын дор Японы засгийн газар «Алс Дорнод» гэсэн нэр томъёоны хүрээг дураар өргөжүүлэх болов. 1969 оны 11-р сард Японы ГЯЯ «Алс Дорнодыг» Японы нутаг дэвсгэр, Филиппинээс умард зүг дэхь газар нутаг, Өмнөд Солонгос ба Тайвань, Хятадын эрэг орчим, Приморье гэж тодорхойлж байсан бол Вьетнамын эсрэг америкийн түрэмгийллийн үед Зүүн Өмнөд Азийг бүхлээр нь багтаах болов.<sup>5</sup> Ийнхүү өргөжин өргөжсөөр 1980 оны 2-р сарын 1-нд Японы Гадаад Явдлын Яамны гэрээ эрхийн хэлтсийн эрхлэгч М. Датэгийн мэдэгдсэнээр «Алс Дорнодын энх тайван, аюулгүй байдалд заналхийлэх онцгой үйл явдал гарч болзошгүй бүх районыг бүхэлд нь онолын хувьд Алс Дорнод гэж үзэх болно»<sup>6</sup> гэжээ. Ийнхүү «Алс Дорнод» гэсэн ухагдахууныг дураар тайлбарлах замаар Япон дахь зэвсэгт хүчнээ дэлхийн бөмбөрцгийн аль ч өнцөг буланд ашиглах боломжийг АНУ-д олгоход бэлэн байгаа явдал нь Японыг америкийн цэргийн ажиллагаанд шууд татан оруулах аюултай юм.

Япон-америкийн харилцааг АНУ-НАТО-гийн олон талын цэргийн хамтын ажиллагааны түвшинд хүргэх гэсэн оролдлогыг Пентагон авч хэрэгжүүлэх болов. 1981 оны 5-р сард Японы ерөнхий сайд Сузуки Вашингтонд ерөнхийлөгч Рейгантай хэлэлцээ хийсний эцэст гаргасан хамтарсан албан мэдээнд япон-америкийн харилцааг дэлхийн II дайнаас хойш анх удаа «холбоо» гэж тодорхойлжээ. Энэ нь өнгөн дээрээ хоёр орны харилцааг эрх тэгш гэсэн мэт боловч хэрэг дээрээ Японыг НАТО-гийн орнуудтай адилтган тэдэнтэй адил цэрэг дайны дарамтыг үүрүүлэх гэсэн хэрэг учраас Азийн энх тайвны үйл хэрэгт ноцтой аюултай юм.

1982 оны 11-р сард Вашингтонд Пентагоны шеф Уайнбергертэй Японы Үндэсний Батлан Хамгаалах Газрын дарга Ито хэлэлцээ хийх үедээ мян. км-ийн радиустай бүсэд цөмийн цохилт хийх чадалтай «Ф—16» сөнөөгч-бөмбөгдөгч онгоцуудыг Японы Хонсю арлын хойд хэсэгт оршдог Мисава баазад 1985 оноос эхлэн байрлуулахаар шийдвэрлэсэн нь<sup>7</sup> Зөвлөлтийн Алс Дорнод болон хөрш зэргэлдээ орнуудын эсрэг шууд чиглэснээрээ хоёр орны цэрэг-улс төрийн хамтын ажиллагааг бэхжүүлэх ээлжит алхам болсон юм. Гэвч Токио үндсэн бүх асуудлаар Вашингтоны бодлогыг аялалдан дагалдаж байна гэж үзэж болохгүй юм. Хоёр орны хооронд худалдаа-эдийн засгийн салбараас эхлэн хэд хэдэн ноцтой зөрчил оршиж байна. 1981 онд АНУ-ын Японтой хийсэн худалдааны алдагдал даруй 16 млрд долларт хүрчээ. АНУ-ын байнгын дефицит тэдний хооронд хурц өрсөлдөөний уур амьсгалыг бий болгож байна.

Нөгөө талаас империализмын төлөвлөлгөөн дэх Өмнөд Солонгосын цэрэг-стратегийн ач холбогдол өсөн нэмэгдсэн нь сүүлийн үед Ази тивд гарсан нааштай өөрчлөлтүүдтэй холбоотой юм. Нэгдмэл социалист Вьетнам улс байгуулагдан, социалист гэр бүлд БНАЛАУ нэмэгдсэн, Кампучид үндэсний дэвшилт хүч ялсан, СЕАТО-гийн цэргийн эвсэл задран нурсан, Афганистан ба Иранд империализмын эсрэг хувьсгал ялснаар Өмнөд Солонгос Ази дахь америкийн сүүлчийн

<sup>4</sup> С. И. Вербицкий. Японо-американский военно-политический союз. с. 274.

<sup>5</sup> «Проблемы Дальнего Востока» 1981, № 1, с. 59—60.

<sup>6</sup> Мөн тэнд.

<sup>7</sup> «Новое время» 1982. № 47, с. 17.

«цайзуудын» нэг болон хувирсан юм. АНУ-Өмнөд Солонгосын цэрэг-улс төрийн харилцааны эрх зүйн үндэс нь 1953 оны 10-р сарын 1-нд байгуулагдсан «харилцан батлан хамгаалах» тухай гэрээ юм.<sup>8</sup> Энэхүү гэрээний дагуу АНУ нь Өмнөд Солонгосын нутаг дэвсгэр дээр цэргийн баазууд байгуулах эрхээ хадгалан үлдсэн бөгөөд Сеулын засгийн газар Алс Дорнод дахь АНУ-ын цэрэг-улс төрийн ямар ч арга хэмжээг дэмжих үүрэг хүлээн авчээ. Энэтхэг-хятадын хойгт америкийн империализмын түрэмгийлэл нуран унасны дараа Өмнөд Солонгосын талаархи АНУ-ын бодлогод чухал өөрчлөлт гарчээ. Тухайлбал АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Киссинджер 1975 оны 5-р сарын 16-нд «Солонгосын аюулгүй байдал нь Номхон далайн баруун хойт хэсгийн аюулгүй байдал болон Зүүн Хойд Ази дахь манай эрх ашигт маш чухал бөгөөд мөн Японтой харилцах манай харилцаанд онцгой чухал»<sup>9</sup> гэж мэдэгдэж байв.

Чухамхүү энэ үеэс эхлэн Вашингтон нь Өмнөд Солонгосын дэглэмийг онцгойлон «хамгаалах» үүргийг Японд тохих замаар Япон-Өмнөд Солонгосын цэрэг-улс төрийн харилцааг бэхжүүлэхээр хүчлэн чармайл болов. Вашингтоны энэ чиг шугам нь АНУ-тай хамтран ажиллах замаар Өмнөд Солонгост өөрийн эдийн засаг, улс төр, стратегийн эрх ашгаа хангах гэсэн Японы эрх баригч бүлгийн санаанд нийцэж байв. Иймээс ч 1975 оны 7-р сарын 23-нд Японы Гадаад Явдлын Яамны сайд К.Миязава Сеулд албан ёсны айлчлал хийж 1973 оны 8-р сард Сеулын тагнуулын газар Өмнөд Солонгосын оппозиц намын зүтгэлтэн Ким Тэ Чжуныг Токиогоос нууцаар хулгайлан авснаас болж мухардаад байсан хоёр орны харилцааг зохицуулан Пакрын дэглэмд эдийн засгийн «тусламж» үзүүлэх явдлаар сэргээхээр хэлэлцэн тохирчээ.<sup>10</sup>

Япон, Өмнөд Солонгосын харилцааны түүхэнд 1975 оны 8-р сард Японы ерөнхий сайдын АНУ-д хийсэн айлчлал онцгой байр эзэлдэг юм. Мики-Фордын хамтарсан мэдэгдэлд «Солонгосын Бүгд Найрамдах Улсын аюулгүй байдал Солонгосын хойгт энх тайвныг сахин хамгаалахаас эхлэн Зүүн Ази, түүний дотор Японы энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах нэн чухал»<sup>11</sup> гэж заажээ. Үүнийг 1969 оны 11-р сарын Никсон-Сатогийн албан мэдээний «Өмнөд Солонгосын аюулгүй байдал нь Японы аюулгүй байдалд амин чухал ач холбогдолтой»<sup>12</sup> гэсэн зүйл ангитай харьцуулан үзвэл Япон болон Өмнөд Солонгосын аюулгүй байдлын уялдаа холбоог зөвхөн Солонгосын хойгийнхтой бус Зүүн Азийнхтай бүхэлд нь хамтатгасан нь илэрхий байна.

Ж. Картерын захиргаа АНУ-ын засгийн эрхэнд гарахдаа Өмнөд Солонгосоос америкийн цэргийг татан гаргах асуудлыг зүй зохистой шийдвэрлэх дүр үзүүлсэн юм. Тухайлбал тэрээр ерөнхийлөгчийн сонгуулийн кампанийн үед америкийн хуурай замын цэрэг, тактикийн цөмийн зэвсгийг хүртэл татан авахыг амлаад зогсоогүй ерөнхийлөгч болсныхоо дараа хүртэл 20 мян. хүнтэй хуурай замын цэргийг 3 жилийн дотор ээлж дараалан татан гаргах болно гэж мэдэгдэж байв.<sup>13</sup> 1977 оны 3-р сард Японы ерөн-

<sup>8</sup> Международные отношения на Дальнем Востоке в послевоенные годы 1945—1957. М., 1978, с. 195.

<sup>9</sup> Д. Т. Капустин. Тайвань и Южная Корея в китайско-американских отношениях. М., 1980. с. 161.

<sup>10</sup> «Япония 1976» Ежегодник М., 1977, с. 88

\*1965 оны 6-р сарын 22-нд Япон-Өмнөд Солонгосын «харилцааг хэвийн болгох тухай гэрээнд» гарын үсэг зурснаар хоёр орны хооронд албан ёсны харилцаа тогтоосон юм.

<sup>11</sup> Международные отношения в Азиатско-Тихоокеанском регионе. М., 1979, с. 98.

<sup>12</sup> «Япония 1976». Ежегодник. М., 1977, с. 86.

<sup>13</sup> “Asian Survey”, march 1981, vol XXI, Number 3, p 325

хий сайд Т. Фукуда Вашингтонд айлчлах үеэр гаргасан хамтарсан албан мэдээнд америкийн хуурай замын цэргийг Өмнөд Солонгосоос татан гаргах асуудлаар «АНУ нь Солонгосын Бүгд Найрамдах Улс болон Японтой зөвлөлдөөн хийсний дараа Солонгосын хойгийн энх тайванд аюул занал учруулахгүй арга замаар байдлыг шийдвэрлэнэ<sup>14</sup> гэж тусгажээ. Мөн энэ удаа Солонгосын хойгийн энх тайван тогтвортой байдлыг сахин хамгаалах нь Япон болон бүх Алс Дорнодын аюулгүй байдалд чухал» болох тухай хэсэгт 1975 оны Мики-Фордын хамтарсан мэдэгдлээс зөрөөтэй нь Өмнөд Солонгосыг дурьдаагүй орхисон нь ажиглагчдын анхаарлыг татаж байв.

1977 оны 5, 7-р сард АНУ-ын өндөр тушаалын төлөөлөгчид цэрэг татан гаргах тодорхой төлөвлөгөөг Токио болон Сеулд хэлэлцсэн байна. Америк-Япон-Өмнөд Солонгосын зөвлөлдөөний үр дүнд Өмнөд Солонгосоос америкийн цэргийг татан гаргах амлалт ба Солонгосын хойг түгшүүртэй байдлыг намжаах мэдэгдэлд итгэх итгэлээс юм үлдээсэнгүй. 1978 оны эцэс гэхэд АНУ нь зөвхөн 6 мян. цэрэг татан гаргах бөгөөд таван жил дараалан хорогдуулсны эцэст Өмнөд Солонгост америкийн голдуу агаарын цэргийн хүчнээс бүрдсэн 13 мян. цэргийн албан хаагч үлдэх болно гэж зарлав.<sup>15</sup> Гэвч АНУ-ын ерөнхийлөгч энэ хугацааг дахин хянаж үзэж болох ба энэ талаар өөрийн бусад холбоотнууд Австрали, Шинэ Зеланд, Тайвантай зөвлөлдөх болно гэж мэдэгджээ. Үүнтэй нэгэн зэрэг Өмнөд Солонгос дахь агаарын хүчээ 1/4 дахин нэмэгдүүлэхээр Пентагон төлөвлөж байв. Мөн Өмнөд Солонгосын армийг нэмж зэвсэглэн, цэргийн тусламжаа эрс нэмэгдүүлснийг тооцвол Өмнөд Солонгос дахь америк-өмнөд солонгосын цэргийн хүчин чадал нилээд нэмэгдсэн нь илэрхий болно. Тухайлбал АНУ-ын конгрессын мэдээгээр 1969-1975 оны хоорондох 7 жилд Өмнөд Солонгост үзүүлсэн тусламж нь урьдах 16 жилийнхээс 2 дахин илүү гарсан бөгөөд 1975 оны дундуур гэхэд 6,5 миллиард долларт хүрч байв.<sup>16</sup>

1978 оны хавраас эхлэн цэргээн татан гаргах «хурдыг сааруулах» тухай америкийн албан хүмүүс байн байн мэдэгдэх болсон бөгөөд 1979 оны эх гэхэд Сеулд гаднын хүчний заналхийлэх «аюулыг дутуу үнэлж байсныг» харуулсан Пентагоны «шинэ мэдээ баримт» гэдгээр шалтаглан Өмнөд Солонгосоос цэргээ татан гаргах асуудлыг дахин хянаж үзэх тухай хэлэлцэх болов. Иймэрхүү мэдэгдлүүдийн дараагаар 1979 оны 6-р сарын 29-нөөс 7-р сарын 1-нд АНУ-ын ерөнхийлөгч болон Батлан Хамгаалах Яамны сайд Өмнөд Солонгост айлчлав.<sup>17</sup> Уулзалтын дүнд мөн чанар ба үзэл санааны хувьд хэт милитарист бөгөөд сүүлийн арван жилд хамгийн «хатуу үгтэй» америк, өмнөд солонгосын хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зуржээ. Тус мэдэгдэлд Өмнөд Солонгосын дэглэмд бүх талын тусламж, юуны өмнө цэргийн тусламж үзүүлэх АНУ-ын чиг шугамд огтхон ч өөрчлөлт гараагүйг Ж. Картер батлан илэрхийлэв. Хоёр тал 1953 оны гэрээний чухлыг тэмдэглээд «АНУ ба Өмнөд Солонгосын цэргийн хамтын ажиллагаа нь энх тайван болон тогтвортой байдлын үйл хэрэгт жинтэй хувь нэмэр оруулж байна» гэв. Энэхүү айлчлалын дараахан АНУ-ын засгийн газар Өмнөд Солонгосоос цэргээ татан гаргах төлөвлөгөөг 1981 он хүртэл бүрмөсөн хойшлуулахаар шийдвэрлэсэнээ албан ёсоор мэдэгджээ. Үүний хамт АНУ-ын захиргаа Япон,

<sup>14</sup> Д. Т. Капустин. Тайвань и Южная Корея в китайско-американских отношениях, с. 170.

<sup>15</sup> Д. Т. Капустин. Тайвань и Южная Корея и Китайско-американских отношениях. с. 171.

<sup>16</sup> Д. Т. Капустин. Тайвань и Южная Корея в китайско-американских отношениях, с. 172.

<sup>17</sup> «Проблемы Дальнего Востока» 1979, № 4, с. 14—15

Өмнөд Солонгосын цэргийн хэлхээ холбоог бэхжүүлэхээр шинэ хүчин чармайлт гаргав.

1979 оны 7 ба 8-р сард Японы Үндэсний Батлан Хамгаалах Газрын дарга Г. Ямасита Өмнөд Солонгос болон АНУ-д айлчилж цэргийн асуудлаар хэлэлцээ хийв.<sup>18</sup> Хоёр орны цэргийн удирдах газрын хооронд дээд хэмжээний албан ёсны уулзалт нээснээр түүний Сеулд хийсэн айлчлал нь онцгой сонирхол татаж байна. Ямастиа Өмнөд Солонгосын Батлан Хамгаалах Яамны сайдтай хэлэлцээ хийснээс гадна Өмнөд Солонгосын цэргийн сургуульд ажиглагчаар оролцжээ. Өмнөд Солонгосоос цэрэг татан гаргах асуудлыг хойшлуулсан Картерын шийдвэрт Японы удирдагчид сэтгэл хангалттай байгааг Ямасита мэдэгджээ. Хоёр тал «батлан хамгаалах асуудал эрхэлдэг албаны хүмүүсийн уулзалтыг хийж байхаас» гадна мэдээ материал солилцох, хоёр орны цэргийн хөлөг онгоцууд харилцан бие биеийн боомтод зочилж байхаар хэлэлцэн тохирчээ. АНУ-д Г. Браун ба З. Бжезинскитэй хийсэн Ямаситагийн хэлэлцээнд Токио-Сеулын хооронд төдийгүй гурван талын үндсэн дээр цэргийн хамтын ажиллагааг зохицуулах асуудлыг авч хэлэлцжээ.

Гурван талын цэргийн хамтын ажиллагаа нь гол төлөв Сеулын армийг «шинэчлэхийн» тулд тус дэглэмд зэр зэвсэг нийлүүлэх, тэдний армиудын хамтын ажиллагааг зохицуулахад чиглэгдэж байна. 1977 он, 1982 оны хавар «онцгой тохиолдолд» хамтран ажиллах зорилгоор АНУ, Япон, Өмнөд Солонгосын тэнгисийн цэргийн хүчнүүд хамтарсан сургууль хийжээ. 1978 оны 11 дүгээр сард Сеулын 600 мян. хүнтэй арми болон тэнд байрласан нийт 40 орчим бааз болон 40 мян. гаруй америкийн цэргийн хамтын ажиллагааг уялдуулахын тулд америк-солонгосын зэвсэгт хүчний нэгдсэн командлал гэгчийг байгуулжээ.<sup>19</sup> Нөгөө талаас цэрэг дайны асуудлаар байр сууриа зохицуулах үүрэгтэй япон-өмнөд солонгосын аюулгүй байдлын асуудлаархи парламентын зөвлөл гэгчийг 1979 оны 4 дүгээр сард байгуулжээ.<sup>20</sup> Мөн Япон, Өмнөд Солонгос, Тайваний парламентын гишүүдийн оролцоотойгоор 1978 онд байгуулагдсан «Зүүн хойд Ази, Номхон далайн районы зөвлөлгөөн»-ий үүрэг ролийг дутуу үнэлж болохгүй.<sup>21</sup> Японы стратегийн судалгааны төвийн дарга С. Канэмару (Үндэсний Батлан Хамгаалах Газрын дарга байсан) удирддаг бөгөөд АНУ-ын төлөөлөгчид ажиглагчаар оролцдог энэ зөвлөлгөөн жил бүрийн хурлаараа тус бүс нутгийн «аюулгүй байдлыг хангах» асуудлаар санал солилцдог байна.

Одоогийн Рейганы захиргааны Азийн стратегид Өмнөд Солонгос гол байрын нэгийг эзэлж байна. Үүнд АНУ-ын цэрэг-стратегийн сонирголоос гадна эдийн засгийн эрх ашиг чухал үүрэг гүйцэтгэж байна. Өмнөд Солонгосын эдийн засагт гадаадын нийт хөрөнгө оруулалтын 25,8 хувийг Америк эзэлж байна. Рейганы анхны гаднын зочин Чон Ду Хсан байсан нь санамсаргүй хэрэг биш юм. Дарангуйлагч Пак Чжон Хиг залгамжилсан Чон Ду Хван 1981 оны 2 дугаар сард Вашингтонд айлчлах үед ерөнхийлөгч Рейган «Өмнөд Солонгосоос америкийн цэргийг гаргахын эсрэг байгаагаа шийдвэртэй илэрхийлж «Сеулын дэглэмийг хойшид «бүх талаар бүрэн дүүрэн» дэмжихээ мэдэгдсэн юм. Хоёр орны цэргийн салбар дахь хамтын ажиллагааг үлэмж өргөжүүлэх асуудлыг авч хэлэлцээд Өмнөд Солонгос, АНУ-ын «аюулгүй байдлын талаархи зөвлөлгөөнийг» 1982 онд хийхээр тогтжээ. Мөн Рейганы захиргаа 1982 оны санхүүгийн жилд Сеулын дэглэмд зэр зэвсэг худал-

<sup>18</sup> «Сэкай» Токио. № 421. 1980 12. 110-р тал (япон хэл дээр)

<sup>19</sup> «Проблемы Дальнего Востока» 1982, А2 2, с. 107

<sup>20</sup> «Проблемы Дальнего Востока» 1981. № 1, с. 61.

<sup>21</sup> «Сэкай» № 421. 1980, 12. 108-р тал. (япон хэл дээр)

дан авахад нь зориулан 167,5 сая долларын зээл олгохоор шийдвэрлэжээ.<sup>22</sup>

Өнгөрсөн 1632 оны эцсээр засгийн эрхэнд гарсан Я. Накасонэ 1983 оны 1-р сард Сеул, Вашингтонд айлчилсан нь Вашингтон-Токио-Сеулын цэрэг-улс төрийн хамтын ажиллагааг зохицуулах чиглэлд практик алхам болов. Ялангуяа Токио-Сеулын харилцаанд «эргэлт» гаргах ёстой Японы ерөнхий сайдын дэлхийн II дайнаас хойш анх удаа Сеулд хийсэн айлчлалын дүнд тус дэглэмд 1982 оноос эхлэн 7 жилийн хугацаанд 4 млрд. долларын эдийн засгийн «тусламж» олгохоор шийдвэрлэжээ.<sup>23</sup> Энэ нь улсын төсвийн 30 гаруй хувийг цэргийн зардалд зардаг Сеулын дэглэмийг санхүүжүүлдэг Вашингтоны үүргийн багагүй хэсгийг Японы тал даана гэсэн үг юм. Накасонэ, Чо Ду Хваны уулзалтын дүнд гаргасан хамтарсан албан мэдээнд «Солонгосын хойгийн энх тайван, тогтвортой байдал нь Японыг оролцуулан Алс Дсрнодын энх тайван, тогтвортой байдалд амин чухал» гэж тодорхойлсоноос гадна Накасонэ энэ санааны дагуу батлан хамгаалах салбар дахь Өмнөд Солонгосын хүчин чармайлтыг албан ёсоор үнэлжээ.<sup>24</sup> Өмнөд Солонгос өөрийн талаа Японы «батлан хамгаалах» бодлогыг ойлгож байгаагаа илэрхийлээд Азийн бусад орнуудыг мөн ойлгуулах талаар хамтран зүтгэхээ мэдэгджээ.

Вашингтонд Накасонэ 1981 оны 5-р сард Рейган-Сузуки нарын тодорхойлсон «холбоотнуудын харилцааны» үндсэн дээр хоёр талын харилцааг цаашид бэхжүүлэхээр тохирчээ. АНУ-д цэргийн зориулалттай нарийн технологи нийлүүлэх тухай Токиогийн саяхны шийдвэрийг Вашингтон зохих ёсоор үнэлсэн боловч Японы эргээс 1000 милийн зайд тэнгисийн эргүүл хийхийн тулд хүчин чармайлтаа идэвхжүүлэхийг шаардсан байна. Накасонэ Вашингтоны шаардлагыг «бүрэн ухамсарлаж» байгаагаа мэдэгдээд зогсоогүй Японыг «нисэх онгоц тээгч живдэггүй хөлөг онгоц» болгон хувиргахаар мэдэгдсэн нь Японы үндсэн хуулийн энх тайванч заалт, ард түмнийх нь эрх ашигт илт харшилсан мэдэгдэл болсон юм.

Дээр өгүүлснээс авч үзвэл АНУ нь Японтой байгуулсан «Аюулгүйн гэрээ», Өмнөд Солонгостой байгуулсан «харилцан батлан хамгаалах» гэрээнүүдийн үндсэн дээр энэ хоёр холбоотонтойгоо харилцаагаа бэхжүүлэхэд онцгой анхаарч иржээ. АНУ-ын бус нутгийн төдийгүй дэлхийн бөмбөрцгийн цэрэг-стратегийн төлөвлөгөөнд Япон нэн чухал роль эзэлж байна. Иймээс Рейгоны зэхиргаа 80-аад оны эцэс гэхэд батлан амгаалах салбарт Японы хүлээсэн «хариуцлагыг» түүний эдийн засгийн хүчин чадлын түвшинд хүргэсэн байхаар хүчлэн чармайлх болов. Үүнд Японы цэрэг, зэвсэглэлийн зардлыг нэмэгдүүлэхээс гадна түүний зэвсэгт хүчний ажиллагааны хүрээг өргөжүүлэх явдал багтаж байна.

Мөн Өмнөд Солонгосын дэглэмийг бүх талаар дэмжин, түүний зэвсэгт хүчнийг шинэчлэхэд идэвхтэй оролцон, хоёр талын цэргийн салбар дахь чармайлтыг нягт зохицуулах чиг шугамыг Вашингтон хэрэгжүүлж байна. АНУ нь Өмнөд Солонгостой харилцах харилцааг Японтой шууд уялдаатай авч үзсээр иржээ. Японы арлууд дээр байрласан америкийн тэнгисийн ба агаарын цэргийн хүчний баазууд Өмнөд Солонгос дахь америкийн зэвсэгт хүчний дэмжлэг болж байна. «Сеулын аюулгүй байдлыг бэхжүүлэхэд» Токиогийн эдийн засгийн тусламж ихээхэн ач холбогдолтой гэж америкийн тал үзэж байна. Японы эрх баригч бүлэг ч Сеултай харьцах харилцааг амин чухал гэж цохон тэмдэглэж байна.

<sup>22</sup> «Улаан од» 1982. 1. 27.

<sup>23</sup> "The Japan Times Weekly" 1983. 1. 15

<sup>24</sup> Мөн тэнд.

Солонгосын хойгийн өмнөд хэсэгт америкийн цэргийг хэвээр хадгалах нь «Зүүн Азийн энх тайван, тогтвортой байдалд» жинтэй хувь нэмэртэй гэж Токио мэдэгдэж байна. Гэвч 70-аад оны сүүлч, 80-аад оны эхээр Сеултэй цэргийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн Японы байр суурийг тодорхой хэмжээгээр тогтоон барих хэдэн хүчин зүйл хүчтэй болж байгааг тэмдэглэх хэрэгтэй. 1-рт, ЗХУ болон БНАСАУ-тай хэвийн харилцаатай байхыг эрмэлзсэн хүчний нөлөө Японд, түүний эрх барих бүлэгт ч ажиглагдаж байна. 2-рт, хоёр, орны хооронд улам бүр хурцдаж байгаа эдийн засаг-худалдааны зөрчил чухал хүчин зүйл болж байна.<sup>25</sup> Ази, Номхон далайд ноёрхлоо тогтоох гэсэн АНУ-ын империализмын Азийн стратегийн дагуу «Зөвлөлтийн аюул» гэгчээр халхавчласан коммунизмын эсрэг үзлийн үндсэн дээр Япон-Өмнөд Солонгосын цэрэг-улс төрийн хамтын ажиллагааг зохицуулах арга хэмжээг шуурхайлан авч байна. Энэ нь эцсийн эцэст Япон-Өмнөд Солонгосын хооронд цэргийн салбарт эрх зүйн үндэс бий болгосноор Вашингтон-Токио-Сеулын цэрэг-улс төрийн холбоог бүрэлдүүлэх аюултай юм. Хэрвээ цэргийн гурамсан холбоо байгуулагдах аваас ЗХУ болон социалист бусад орнууд, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эсрэг шууд чиглэхээс гадна тус бүс нутгийн орнуудын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолд заналхийлэн Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдал ноцтой аюулд учрах юм. Мөн Пентагон болон Японы цэргийн эрхтнүүд тус гурван орноос гадна АНУ-тай АНЗЮС-ын гэрээгээр холбоотой Австрали, Шинэ Зеланд, тэр ч байтугай АСЕАН-ы таван орныг нэгтгэсэн «Номхон далайн нийгэмлэг» гэгчийг байгуулах санаа өвөрлөж байгаа юм.

Иймээс ч Алс Дорнод дахь Вашингтоны харгис үйл ажиллагааг таслан зогсоохын төлөө тэмцэл нь Ази болон даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахын төлөө тэмцлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ нь юуны өмнө Солонгосын өмнөд хэсгээс америкийн цэргийг гарган Солонгосыг гаднын оролцоогүй энх тайван замаар нэгтгэхийн төлөө тэмцэлтэй нягт холбоотой юм. «Үндэснийхээ хүсэл эрмэлзлийг биелүүлэхийн төлөө, улс орноо эв зүйгээр, ардчилсан ёсоор, гаднын оролцоогүйгээр нэгтгэхийн төлөө солонгосын ард түмний тэмцлийг бид хойшид ч тал бүрээр дэмжих болно»<sup>26</sup> гэж нөхөр Ю. Цэдэнбал МАХН-ын XVIII их хурал дээр цохон тэмдэглэсэн юм.

ЗХУ ах дүү социалист бусад орнууд Ази тивд бий болсон түгшүүртэй байдлын голомтыг арилган, маргаантай асуудлыг улс төрийн аргаар зохицуулах явдлыг одоогийн хамгийн тулгамдсан зорилт гэж үзэж байна. ЗХУКН-ын XXVI их хурлаас боловсруулсан 80-аад оны энх тайвны Программд Алс Дорнодод итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай ЗХУ-ын дэвшүүлсэн оновчтой санал нь энэ зорилтод чиглэсэн чухал хүчин зүйл болж байна. МАХН-ын XVIII их хурлаар Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц боловсруулж байгуулах талаар дэвшүүлсэн санал дээрхи саналтай нягт уялдан зохицсон юм. Энэ зорилгоор тус бүс нутгийн улс орны бага хурлыг хуралдуулж, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн бүх гүрнийг урьж оролцуулахын чухлыг заасан юм. Манай улс энэ саналаа хэрэгжүүлэхийн тулд идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлж байгаа бөгөөд тэр нь социалист хамтын нөхөрлөлийн орнууд болон тус тивийн бодит бодлого баримталдаг улс гүрэн, Азийн дэвшилт олон нийтийн дэмжлэгийг зүй ёсоор хүлээж, уг санал Азийн, ялангуяа Алс Дорнодын аюулгүй байдлын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлэх үр нөлөөтэй нэг арга зам байж болохоо харуулж байна.

## ПОЛИТИКА ПАРТНЕРСТВА США НА ДАЛЬНЕМ ВОСТОКЕ

( Р е з ю м е )

В современной международной обстановке Дальний Восток занимает весьма важное место, ибо здесь соприкасаются интересы многих государств азиатско-тихоокеанского региона.

США, стремясь усилить свое присутствие в этом районе, предпринимают все возможные меры для сохранения и упрочения военно-политических союзов с Японией и Южной Кореей, наращивания американских военных баз и вооруженных сил на этих территориях, тем самым нагнетая международную обстановку и в этой части мира.

Политика партнерства США на нынешнем этапе ярко проявляется, с одной стороны, в укреплении военно-политического союза с Японией на основе «договора безопасности» 1960 года, в расширении сферы действия договора, с целью подключения Японии к глобальной стратегии США, а с другой стороны, во всесторонней поддержке реакционного южнокорейского режима, предоставлении ему новых кредитов для модернизации вооруженных сил. К тому же от Японии требуется увеличить ее «вклад» в укрепление Сеульского режима.

Отсюда налицо возрастающее военно-политическое сотрудничество США, Японии и Южной Кореи. Эта политика своим острием направлена прежде всего против социалистических стран Азии, против сил демократии и национального освобождения в этом регионе. Она также несовместима и с национальными интересами других стран Азии и Тихого Океана. Разумную альтернативу империалистическим замыслам в Азии предлагают социалистические страны. XXVI съезд КПСС сформулировал Программу мира на 80-ые годы, которая, в частности, включает проведение переговоров по мерам доверия на Дальнем Востоке.

Предложение МНР о заключении конвенции о взаимном ненападении и неприменении силы в отношениях между государствами Азии и Тихого океана полностью отвечает интересам народов стран Дальнего Востока и направлено на ослабление напряженности в Азии.

Монгольский народ твердо уверен, что отказ от планов милитаризации, установления военного превосходства, политического нажима в международных отношениях, послужит надежной основой нормализации политической обстановки на всем азиатском континенте.